



НЭГЖ СЭДЭВ: ЖИНХЭНЭ НЭР

**ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ:
ЖИНХЭНЭ НЭРИЙН ОЛОН ТООНЫ
НӨХЦӨЛ**

**Ээлжит хичээлийн зорилго:
Жинхэнэ нэрийн олон тооны
нөхцөлийг хэрэглэх**

ДАРААХ ОНОЛЫН ОЙЛГОЛТЫГ ДЭВТЭРТЭЭ ТЭМДЭГЛЭЖ АВААРАЙ.

- ◎ **Үгийн бүтэц:** Монгол хэл бол залгамал бүтэцтэй. Тиймээс үгийн бүтэц нь язгуур+ үг бүтээх дагавар+ нөхцөл гэсэн дараалалтай байна. Тиймээс жинхэнэ нэр нь язгуур+ **тоо+ тийн ялгал+ хамаатуулах** гэсэн бүтцийн дараалалтай байдаг.
- ◎ **Олон тооны дагавар:** Хүн, юмны ерөнхий олныг илтгэх утгатай бүтээврийг хэлнэ.



ДАРААХ ҮЛГЭРИЙН ХЭСГИЙГ УНШААД, ОЛОН ТООНЫ ДАГАВРЫН ХЭЛ ЗҮЙН ШИНЖ, НАЙРУУЛГЫН ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛООРОЙ.

Гэр

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ. Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ “Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно.” гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. “Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа.” гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.



ДАРААХ ОНОЛЫН ОЙЛГОЛТЫГ ДЭВТЭРТЭЭ ТЭМДЭГЛЭЖ АВААРАЙ.

- ◎ **Үгийн бүтэц:** Монгол хэл бол залгамал бүтэцтэй. Тиймээс үгийн бүтэц нь язгуур+ үг бүтээх дагавар+ нөхцөл гэсэн дараалалтай байна. Тиймээс жинхэнэ нэр нь язгуур+ **тоо+ тийн ялгал+ хамаатуулах** гэсэн бүтцийн дараалалтай байдаг.
- ◎ **Олон тооны дагавар:** Хүн, юмны ерөнхий олныг илтгэх утгатай бүтээврийг хэлнэ.



ДАРААХ ОНОЛЫН ОЙЛГОЛТЫГ ДЭВТЭРТЭЭ ТЭМДЭГЛЭЖ АВААРАЙ.

- ◎ **Үгийн бүтэц:** Монгол хэл бол залгамал бүтэцтэй. Тиймээс үгийн бүтэц нь язгуур+ үг бүтээх дагавар+ нөхцөл гэсэн дараалалтай байна. Тиймээс жинхэнэ нэр нь язгуур+ **тоо+ тийн ялгал+ хамаатуулах** гэсэн бүтцийн дараалалтай байдаг.
- ◎ **Олон тооны дагавар:** Хүн, юмны ерөнхий олныг илтгэх утгатай бүтээврийг хэлнэ.



**АЛХАМ 1: “ГЭР” ҮЛГЭРЭЭС ЕРӨНХИЙ ОЛНЫ УТГАТАЙ ҮГСИЙГ ТҮҮЖ БИЧЭЭД,
БҮТЦЭЭР ЗАДЛААРАЙ.**

ХӨВГҮҮН+Д, УУЛ+С,


.....

**Олон тооны
дагаврууд:**

-ууд, -үүд,
-чууд, -чүүд,
-д,
-с,
-нар

Үгэнд тооны дагавар залгаж
ерөнхий олон тооны утга
бүхий үгийг үүсгэдэг.

**Жишээ нь: эмч нар,
үйлдвэрүүд, монголчууд**



АЛХАМ 2: ДАРААХ ҮГСИЙГ ОЛОН ТООНЫ НӨХЦӨЛӨӨР ХУВИЛГААД, ТУС БҮР 2, 2 ӨГҮҮЛБЭР ЗОХИОГООРОЙ.

- ширээ, хаалга, салаа, хуруу, ямаа
- сандал, цонх, үзэг, ном, сан, хүүхэд
- малчин, нохой, нөхөр, морь, үсчин
- Багш, эмч, ээж, аав, эгч
- Нялх, цэцэг, зүйл, уул, үүл
- Залуу, баатар, эмэгтэй, эрэгтэй, өвгөн,



**АЛХАМ 3: ОЛОН ТООНЫ НӨХЦӨЛИЙГ НАЙРУУЛГАД ЗӨВ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ
ТАЙЛБАРЫГ УНШААД, ЖИШЭЭГ ЗӨВ БОЛГОЖ ЗАСААРАЙ**

1. Өмнөө тооны нэр болон ерөнхий олны утгатай үг авсан жинхэнэ нэр олон тооны нөхцөлөөр хувилахгүй.	а) Зарим оюутнууд хичээлээ сонгоно. Гучаад сурагчид суралцана.	
2. Өгүүлэхүүн нь бэлч, тарх, бөөгнө, барилд, уралд, багшир гэх мэт үйл үгээр илэрсэн байвал үйлийн эзэн болж байгаа жинхэнэ нэр олон тооны нөхцөл авахгүй.	а) Малууд бэлчинэ. Бөхчүүд барилдана.	
3. Нэг үгэнд олон тооны нөхцөлийг давхарлан залгахгүй.	а) Бид нар хичээлдээ явна.	
4. Тодруулсан үгийг давтсан тохиолдолд олон тооны нөхцөлөөр хувилахгүй.	а) Өндөр өндөр уулс, өргөн өргөн голуудыг гатална.	



АЛХАМ 4: ДАРААХ ҮГСИЙГ АЖИГЛААД, ОЛОН ТООНЫ НӨХЦӨЛӨӨР ХУВИЛГАЖ БОЛОХ ЭСЭХИЙГ ТАЙЛБАРЛААРАЙ.

Олон тооны дагаврууд: -ууд, -үүд, -чууд, -чүүд, -д,-с, -нар,

гурил, будаа, цас, элс, шороо

нар, сар, дэлхий, алтан гадас


хөдөөнийхөн, ахынхан, багачууд

Монгол хэлэнд тодорхойгүй олон тооны утга илэрхийлсэн нэр үгс байдаг.

Жишээ нь: адуу, тэмээ, сүрэг, ногоо

Монгол хэлэнд ганц, хос гэсэн утга илэрхийлсэн үгс байдаг. Эдгээр үг үндсэн утгаараа байхдаа олон тооны нөхцөлөөр хувилахгүй.

Жишээ нь: нар, дэлхий, нүд, оймс



ДАРААХ БҮДҮҮВЧИЙГ АЖИГЛААД, ХИЧЭЭЛЭЭ ДҮГНЭЭРЭЙ.

